

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	14
3.4. Материаллаг байдал.....	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	16
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	18
Аудитын зөвлөмж.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	19
4. Менежментийн захидал	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН ХҮҮХЭЛДЭЙН ТЕАТРЫН
ДАРГА М.ОТГОНЧИМЭГ ТАНАА

2021.02.25 № 07/569
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын хүүхэлдэйн театрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын хүүхэлдэйн театрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Байгууллага нь үндсэн чиг үүрэг, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтуудын хүрээнд 24 арга хэмжээ зохион байгуулж, биелэлт 100 хувьтай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>29,577,141.92</u>	<u>40,884,293.92</u>
33	АВЛАГА	00.00	7,000,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	7,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	29,577,141.92	33,884,293.92
351	Түүхий эд материал	2,330,488.92	2,197,542.92
35110	Тусгай зориулалттай материал	2,330,488.92	1,982,542.92
35130	Эм боох материал	00.00	215,000.00
354	Хангамжийн материал	27,246,653.00	31,686,751.00
35410	Бичиг хэргийн материал	382,120.00	1,600,520.00
35420	Аж ахуйн материал	202,138.00	1,367,967.00
35440	Түлш, шатах тослох материал	1,225,000.00	1,055,000.00
35450	Барилгын засварын материал	3,594,115.00	2,954,420.00
35470	Бусад хангамжийн материал	21,843,280.00	24,708,844.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>102,955,695.63</u>	<u>115,618,054.20</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	102,955,695.63	115,618,054.20
392	Биет хөрөнгө	90,865,695.63	106,573,054.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,200,000.00	4,200,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(17,500.00)	(227,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	687,151,487.00	649,556,321.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(669,315,291.95)	(630,281,007.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57,854,385.00	42,085,885.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(42,967,131.88)	(30,091,507.92)
39214	Бусад үндсэн хөрөнгө	91,921,958.00	108,387,858.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(40,615,148.54)	(40,271,032.68)
39217	Ном	2,652,938.00	3,214,038.00
393	Биет бус хөрөнгө	12,090,000.00	9,045,000.00
39301	Програм хангамж	13,170,000.00	13,170,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,080,000.00)	(4,125,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>132,532,837.55</u>	<u>156,502,348.12</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>132,532,837.55</u>	<u>156,502,348.12</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	132,532,837.55	156,502,348.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	810,567,666.94	810,567,666.94
51101	Өмч: - төрийн	810,567,666.94	810,567,666.94
512	Хуримтлагдсан үр дүн	(679,653,410.39)	(654,548,672.82)
51210	Өмнөх үеийн үр дүн	(787,856,635.25)	(678,518,183.39)
51220	Тайлант үеийн үр дүн	108,203,224.86	23,969,510.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,618,581.00	483,354.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>132,532,837.55</u>	<u>156,502,348.12</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	697,016,100.00	602,760,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	697,016,100.00	602,760,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	443,423,100.00	515,690,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	443,423,100.00	515,690,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	253,593,000.00	87,070,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	35,000,000.00	26,120,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	218,593,000.00	60,950,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	588,812,875.14	578,755,489.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	588,812,875.14	578,755,489.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	549,419,233.38	487,549,742.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290,477,554.47	361,771,967.18
210101	Үндсэн цалин	205,290,378.08	241,994,515.28
210102	Нэмэгдэл	68,613,676.39	90,010,251.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,573,500.00	29,767,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,745,104.60	44,946,785.83
210201	Тэтгэврийн даатгал	27,633,475.60	30,690,628.76
210202	Тэтгэмжийн даатгал	3,251,120.66	3,610,662.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,707,902.88	2,888,529.76
210204	Ажилгүйдлийн даатгал	650,364.13	705,178.61
210205	Эрүүл мэндийн даатгал	6,502,241.33	7,051,786.52
2104	Хангамж, бараа материалын зардал	9,400,398.00	8,062,607.00
210401	Бичиг хэрэг	2,942,090.00	1,378,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,042,500.00	2,418,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,548,000.00	1,347,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,867,808.00	2,917,507.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,365,580.00	1,889,695.00
210604	Урсгал засвар	10,365,580.00	1,889,695.00
2107	Томилолт, зочны зардал	7,068,200.00	00.00
210702	Дотоод албан томилолт	7,068,200.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	184,050,140.00	49,965,846.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	181,978,540.00	46,171,946.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	3,040,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	240,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	831,600.00	753,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,312,256.31	20,912,841.05

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,374,100.00	1,374,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,938,156.31	19,538,741.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,393,641.76	91,205,746.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,099,000.00	2,225,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,910,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,189,000.00	2,225,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	294,641.76	88,980,746.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	294,641.76	88,970,746.99
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт санхүүжилт/		10,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>108,203,224.86</u>	<u>24,004,510.95</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	35,000.38
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	35,000.38
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	(35,000.38)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>108,203,224.86</u>	<u>23,969,510.57</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	697,016,100.00	602,760,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	697,016,100.00	602,760,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	443,423,100.00	515,690,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	443,423,100.00	515,690,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	253,593,000.00	87,070,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	35,000,000.00	26,120,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	218,593,000.00	60,950,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	633,590,160.00	570,523,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	633,590,160.00	570,523,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	593,881,518.24	472,318,153.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	327,460,700.00	361,771,967.18
210101	Үндсэн цалин	251,645,900.00	266,066,190.91
210102	Нэмэгдэл	52,378,800.00	72,269,776.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,436,000.00	23,436,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,637,958.24	44,946,785.83
210201	Тэтгэврийн даатгал	27,633,475.60	30,690,628.76
210202	Тэтгэмжийн даатгал	3,251,120.66	3,610,662.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,600,756.52	2,888,529.76
210204	Ажилгүйдлийн даатгал	650,364.13	705,178.61
210205	Эрүүл мэндийн даатгал	6,502,241.33	7,051,786.52
2104	Хангамж, бараа материалын зардал	8,889,010.00	9,396,200.00
210401	Бичиг хэрэг	1,380,000.00	1,022,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,500,000.00	2,248,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,548,000.00	1,347,500.00
210404	Ном, хэвлэл	440,000.00	203,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,021,010.00	4,573,700.00
2105	Нормативт зардал	3,525,000.00	3,215,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,525,000.00	3,215,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,860,900.00	1,250,000.00
210604	Урсгал засвар	13,860,900.00	1,250,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,068,200.00	00.00

210702	Дотоод албан томилолт	7,068,200.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	191,065,650.00	50,363,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	188,994,050.00	46,570,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	3,040,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	240,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	831,600.00	753,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,374,100.00	1,374,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,374,100.00	1,374,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,708,641.76	98,205,746.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,414,000.00	2,225,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,910,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,504,000.00	2,225,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	294,641.76	95,980,746.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	294,641.76	88,970,746.99
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг / нэмэлт санхүүжилт /		7,010,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>63,425,940.00</u>	<u>32,236,100.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	63,425,940.00	32,236,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	63,425,940.00	32,236,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	63,425,940.00	32,236,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	63,425,940.00	32,236,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(63,425,940.00)</u>	<u>(32,236,100.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	810,567,666.94	1,618,581.00	(787,856,635.25)	24,329,612.69
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	810,567,666.94	1,618,581.00	(787,856,635.25)	24,329,612.69
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	108,203,224.86	108,203,224.86
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	810,567,666.94	1,618,581.00	(679,653,410.39)	132,532,837.55
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,135,227.00	1,135,227.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	810,567,666.94	1,618,581.00	(678,518,183.39)	133,668,064.55
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	(1,135,227.00)	00.00	(1,135,227.00)
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	23,969,510.57	23,969,510.57
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	810,567,666.94	483,354.00	(654,548,672.82)	156,502,348.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	560,290,000.00	426,719,253.01	133,570,746.99	76.2
УРСГАЛ ЗАРДАЛ	560,290,000.00	426,719,253.01	133,570,746.99	76.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	559,880,000.00	426,309,253.01	133,570,746.99	76.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	388,282,300.00	361,771,967.18	26,510,332.82	93.2
Үндсэн цалин	267,847,200.00	266,066,190.91	1,781,009.09	99.3
Нэмэгдэл	96,999,100.00	72,269,776.27	24,729,323.73	74.5
Унаа хоолны хөнгөлөлт	23,436,000.00	23,436,000.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,882,600.00	44,946,785.83	7,935,814.17	85.0
Тэтгэврийн даатгал	37,218,600.00	30,690,628.76	6,527,971.24	82.5
Тэтгэмжийн даатгал	3,917,800.00	3,610,662.18	307,137.82	92.2
ҮОМШӨ-ний даатгал	3,134,200.00	2,888,529.76	245,670.24	92.2
Ажилгүйдлийн даатгал	776,600.00	705,178.61	71,421.39	90.8
Эрүүл мэндийн даатгал	7,835,400.00	7,051,786.52	783,613.48	90.0
Хангамж, бараа материалын зардал	9,957,300.00	9,957,300.00	-	100.0
Бичиг хэрэг	1,022,900.00	1,022,900.00	-	100.0
Тээвэр, шатахуун	2,248,800.00	2,248,800.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,347,500.00	1,347,500.00	-	100.0
Ном, хэвлэл	764,400.00	764,400.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,573,700.00	4,573,700.00	-	100.0
Нормативт зардал	3,215,200.00	3,215,200.00	-	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,215,200.00	3,215,200.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	1,250,000.00	1,250,000.00	-	100.0
Урсгал засвар	1,250,000.00	1,250,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	102,918,500.00	3,793,900.00	99,124,600.00	3.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	99,124,600.00	00.00	99,124,600.00	0.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,040,000.00	3,040,000.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	753,900.00	753,900.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1374100.00	1374100.00	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,374,100.00	1,374,100.00	-	100.0

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	410000.00	410,000.00	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	410,000.00	410,000.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	410,000.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	560,290,000.00	426,719,253.01	133,570,746.99	76.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	560,290,000.00	426,719,253.01	133,570,746.99	76.2
Улсын төсвөөс санхүүжих	560,290,000.00	426,719,253.01	133,570,746.99	76.2
АЖИЛЛАГСАДЫН ТОО	31	31	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	20	20	-	100.0
Үйлчлэх ажилтан	10	10	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

төгрөгөөр

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Тайлант он
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		87,070,000.00
УРСГАЛ ЗАРДАЛ		87,070,000.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		78,245,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал		6,947,500.00
Багаж, техник, хэрэгсэл		6,947,500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		71,297,500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		71,297,500.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		8,825,000.00
Бусад урсгал шилжүүлэг		8,825,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,815,000.00
Төвлөрүүлэх шилжүүлэг / нэмэлт санхүүжилт /		7,010,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		87,070,000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		87,070,000.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		26,120,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		60,950,000.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		0.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын хүүхэлдэйн театрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Улсын хүүхэлдэйн театрын дарга М.Отгончимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд бараа материал, үндсэн хөрөнгийн ангилал, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар “Шинэ их тэрбум аудит” ХХК-ийн ахлах аудитор Ц.Мишигдорж, аудитор Т.Меруерт нар хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын хүүхэлдэйн театрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 09 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Улсын хүүхэлдэйн театрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үе үеийн хүүхэд багачуудад дэлхийн болон үндэсний сонгодог уран бүтээлүүдээр дамжуулж урлаг, гоо зүйн мэдрэмжийг олгох;
- Мэргэжлийн урлагийн байгууллага, хүүхэлдэйн урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллага хүмүүс, уран бүтээлчид, ажилтнуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор судалгаа хийн, сургалт явуулж, мэдээлэл арга зүйн удирдамжаар хангах;
- Эх орны болон дэлхийн сонгодог урлаг, соёлын ховор нандин өв, эх сурвалжийг эрэн сурвалжилж, театрын сан хөмрөгт хадгалагдаж буй урлагийн бүтээлийг сэргээх, баяжуулах, мэдээллийн сан бий болгох.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
- Коронавируст халдварын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 168 дугаар тогтоол
- Халдвараас урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 171 дүгээр тогтоол

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Улсын хүүхэлдэйн театр санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн боловч өөрийн байгууллагын онцлогт тохирсон зарим заалт байхгүй байна.

Соёлын яамны Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас 2020 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар Улсын хүүхэлдэйн театрын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 86.6 хувьтай буюу “Сайн” гэж дүгнэн цаашид анхаарах алдаа, зөрчилтэй асуудлыг танилцуулсан байв.

Улсын хүүхэлдэйн театрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ .

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн санхүүгийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 578,790.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 11,575.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улсын хүүхэлдэйн театрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,969.5 мянган төгрөгөөр буюу 18.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцооны данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага		7,000.0	7,000.0
Бараа материал	29,577.1	33,884.3	4,307.2
Үндсэн хөрөнгө	102,955.7	115,618.0	12,662.3
Нийт хөрөнгө	132,532.8	156,502.3	23,969.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	132,532.8	156,502.3	23,969.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	132,532.8	156,502.3	23,969.5

Авлага дансны үлдэгдэл 7,000.0 мянган төгрөг болж, 7,000.0 мянган төгрөгөөр өссөн нь оны сүүлд буцаж орж ирсэн нэр данс зөрүүтэй Соёлын яамнаас авах авлага юм.

Бараа материалын дансны үлдэгдэл 33,884.3 мянган төгрөг болж 4,307.2 мянган төгрөгөөр өссөн нь үзвэрийн билет, ажилчдын нормын хувцас, бичиг хэргийн материал, КОВИД 19-ийн халдвараас урьдчилан сэргийлэх зориулалттай эм бэлдмэл ариутгалын бодис хамгаалах, бусад хангамжийн материалын шинээр худалдаж авснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 2019-2020 онд худалдаж авсан ашиглалтгүй 2,724.3 мянган төгрөгийн 7,496 ширхэг үзвэрийн 13 төрлийн билет, 250 ш ойн медаль, жүжигчдийн хувцас дагалдах хэрэгсэл байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 115,618.0 мянган төгрөг болж 12,662.3 мянган төгрөгөөр өссөн нь шинээр хөрөнгө худалдан авсан, жүжгийн уран бүтээл бэлтгэснээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 24,727.5 мянган төгрөгийн урлагийн бүтээл, урсгал төсвийн худалдан авалтаар 7,508.6 мянган төгрөгийн компьютер техник хэрэгслийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөнөөс Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрлөөр 68,572.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

Тайлант онд биет бус хөрөнгө 3,045.0 мянган төгрөгийн хорогдлын зардлаар буурчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 156,502.3 мянган төгрөг болж 23,969.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

Улсын хүүхэлдэйн театрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 94,266.1 мянган төгрөгөөр буюу 13.5 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нэмэлт санхүүжилтийн орлого, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого байна. Энэ нь КОВИД 19 цар тахлын улмаас Засгийн газраас 2020 оны 1-2 дугаар улирал, 11-12 саруудад хөл хорио тогтоож, аливаа үйл ажиллагаа түр зогсонги байсантай холбоотой юм.

Нийт зардал өмнөх оноос 10,067.4 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар буурчээ. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, томиллолт, урсгал засвар, хангамжийн бараа материал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлууд байна. Энэ нь санхүүжилт буурсан, үндсэн үйл ажиллагаа зогсонги байснаас шалтгаалсан.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,026,969.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,026,969.8 мянган төгрөгөөр тоцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 455,660.5 мянган төгрөгөөр бууруулж 571,309.3 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төслийн санал буурсан шалтгаан нь доорх зардлуудын санхүүжилт батлагдаагүйтэй холбоотой байна. Үүнд:

- Шинээр нэмэгдэх орон тооны цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 144,320.7 мянган төгрөг;
- Урсгал засвар, багаж техникийн тавилга эд хогшил бэлтгэх 127,998.0 мянган төгрөг
- Албан томилолтын зардал 140,701.8 мянган төгрөг
- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал 18,948.0 мянган төгрөг
- Гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 34,184.5 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын баталсан “Коронавируст халдварын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” 2020 оны 168 дугаар тогтоолд заасны дагуу зохицуулалт хийгдсэнээс шалтгаалжээ.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Бидний театр” төсөл, “ Үлгэрийн баатрууд амилсан нь” уралдаан, Хүүхэлдэйн урлагийн медиа контент арга хэмжээг санхүүжүүлэхээр 426,719.2 мянган төгрөгийн төсөв баталсан үүнийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 560,290.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 426,719.2 мянган төгрөгийг зарцуулж 88,970.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 426,719,2 мянган төгрөг буюу 76.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 26,510.3 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 7,935.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 44,600.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь шинэ уран бүтээл хийх бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр 99,124.6 мянган төгрөг, цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 34,446.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Гадаад төсөл хөтөлбөрөөс 32,445.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 25,000.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 29,625.0 мянга, нийт 87,070.0 мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс техник хэрэгсэл, тоног төхөөрөмжид 6,947.5 мянга, маркетингийн зардалд 8,185.0 мянга, жүжгийн хувцас хийлгэх, тайз хийлгэхэд 62,362.5 мянга, тоглолтын тасалбарт 750.0 мянга, тэтгэмж шагнал урамшуулалд 1,815.0 мянга, нийт 80,060.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 7,010.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 20 нэр төрлийн 149 талбарт оруулах мэдээллээс хугацаандаа оруулсан боловч үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг бүрэн хангаагүй байна.

Шилэн дансны мэдээллийг бүртгэл тайлан, анхан шатны баримттай тулган шалгахад 672,822.5 мянган төгрөгийн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын мэдээллээс шилэн дансанд төсвийн санхүүжилтийн орлогыг бүрэн мэдээлж, нэмэлт санхүүжилтийн орлого 49,935.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, 89,462.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ болон худалдан авалтын үйл ажиллагааны тайланг тус тус мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 764.0 мянган төгрөгийн зөрчилд 764.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг тогтоон төлж барагдуулсан байна. Аудитаар өгсөн 5 зөвлөмжийн хэрэгжилт 60% хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	764.0	1	764.0	-	-	100%
Зөвлөмж	5	-	3	-	2	-	60%
Нийт дүн	6	764.0	4	764.0	2	-	80%

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт бүрэн нийцээгүй, өөрчлөн сайжруулах, үндсэн үйл ажиллагааны орлогыг и-баримтын бүртгэл тайланд дутуу тусгадаг, анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулах зэрэг 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 177,100.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3,500.0 мянган төгрөгийн дүнтэй өмнөх зөвлөмжийн дутуу хэрэгжилтэд 2 албан шаардлага, шилэн дансны мэдээлэл байршуулаагүй 139,397.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, нээлттэй тендер зарлаагүй 17,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 17,202.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 4 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 177,100.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 159,897.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

- 2019 оны 02-р сарын 04-ны өдрийн А/64 тоот тушаалаар батлан мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт бүрэн нийцээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл 18.2. *“Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.”* гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх.

- Мөн Баянхонгор аймгийн Тэмүүжин театраас хүлээн авсан хүүхэлдэйн жүжгийн франчайзын орлого 3,000.0 мянган төгрөгийг мөн Дэлхийн зөн ОУБ-аас орж ирсэн тоглолтын тасалбарын үнэ 500.0 мянган төгрөгийг и-баримтаар бүртгээгүй өмнөх зөвлөмжийг дутуу хэрэгжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5. *“Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна;”* 13.7. *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх,*

санхүүгийн тайланд тусгахыг хориглоно; гэсэн заалттай нийцэхгүй үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.
Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

3. 2020 оны шилэн дансны сайтад зохих мэдээллийг цаг хугацаанд нь оруулсан боловч 139,397.5 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3. тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" заалттай нийцэхгүй үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

4. Гүүд Нэйборс ОУТББ-ын Монгол дахь төлөөлөгчийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлсэн 17,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Миний хөөрхөн шүдний аялал" 20 ангит жүжгийн төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг байнгын харилцдаг 3 аж ахуйн нэгжид "үнийн санал авах тухай" албан тоот хүргүүлж, нээлттэй цахим тендер зарлаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн "6.1.Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.; 8 дугаар зүйлийн 8.2. "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ". 8.4."Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно" заалтуудыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 17,202.6 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбоотойгоор 2021 оны хаврын чуулганаар хуулийн төслийг хэлэлцэхээр төлөвлөсөн тул шинэчилсэн хуультай холбоотойгоор соёлын газрын чиг үүрэг, дотоод зохион байгуулалтын бүтэц өөрчлөлттэй холбоотой асуудлуудыг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн зарлагын 720.0 мянган төгрөгийн дүнтэй гүйлгээ төлбөрийн и-баримтаар баталгаажуулж болон дэмжих анхан шатны баримтгүй. Энэ нь үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.” 13.5. “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна;” 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” заалтыг тус тус зөрчсөн.

1.2. Эрсдэл:

Анхан шатны баримтыг хуулийн дагуу хүчин төгөлдөр бүрдүүлээгүйгээс орлого, зардлыг хүлээн зөвшөөрөхгүйд хүрэх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу мөнгөн хөрөнгийн зарлагын баримтыг бүрэн бүрдүүлж, төлбөрийн и-баримтаар баталгаажуулж, хавсаргаж байх;

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Ковид-19 цар тахлаас шалтгаалан бараа материал худалдан авсан байгууллагын үйл ажиллагаа зогссоноос холбогдож чадаагүй асуудал үүссэн. Анхаарч ажиллана.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бараа материал дансанд 8,589.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материал дансанд ангилал буруу илэрхийлсэн. Мөн Бараа материалын тайлангаар 7496 ш тоглолтын тасалбар хөдөлгөөн ороогүй, зарим тасалбарын нэр төрөл, үнэ тодорхой бус бүртгэгдсэн; 250 ш ойн баярын медаль болон 3,214.3 мянган төгрөгийн бусад эд зүйл он дамжин бүртгэгдэж, хэрэгцээ шаардлага хангах эсэх нь тодорхойгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тоот тушаалаар баталсан Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааврын “2.6 Хангамжийн материал: аж ахуйн үйл ажиллагаанд ашиглагдах, цаашидаа зардал болгох хангамжийн материал, шууд зарцуулагдах багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, шатах тослох материал, бусад хангамжийн шинжтэй зүйлс хамаарна” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “толилуулга ба тодруулга”, “үнэн зөв байдал”, оршин байх, үнэлгээ, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:

Хөрөнгийн ангиллыг буруу тогтоосноор санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд зөрүүтэй илэрхийлэгдсэн.

2.3. Өгсөн зөвлөмж

УСНББОУС 12. Бараа материал. 9-р параграф *“Бараа материал гэдэг нь дараах хөрөнгүүд юм. .../б/ Үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулах буюу түгээн хуваарилагдах материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа;”* гэж заасны дагуу бараа материалыг үнэн зөв ангилж байх;

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тухайн хөрөнгүүдийг 2021 оны 1 дүгээр улиралд үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэнэ. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор 2020 онд тоглогдохоор төлөвлөгдсөн жүжгүүд тоглогдоогүйн улмаас тасалбарт хөдөлгөөн ороогүй. 70 жилийн ойн медалийг дараагийн ой болох 80 жил хүртэл ашиглахаар төлөвлөж хэвлүүлсэн.

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд 3,214.0 мянган төгрөгийн үнэ бүхий ном, гарын авлагыг үндсэн хөрөнгө дансанд ангилал буруу бүртгэсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3.2. *“санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах;”*, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаал *“Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг зөрчсөн, үнэн зөв, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.*

3.2. Эрсдэл:

Хөрөнгийн ангиллыг буруу тогтоосноор санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд зөрүүтэй илэрхийлэгдсэн.

3.3. Өгсөн зөвлөмж:

УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө 13-р параграф. *“Үндсэн хөрөнгө гэдэг нь дараах шинжтэй биет зүйлсийг хэлнэ. Үүнд: а. Бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэд ашиглах, бусдад түрээслэх эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа, б. Нэгээс дээш тайлант үед ашиглагдахаар хүлээгдэж буй;”* гэж заасны дагуу үндсэн хөрөнгийг үнэн зөв ангилж бүртгэх;

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2021 оны 1 дүгээр улиралд бараа материалын дансанд шилжүүлэн бүртгэнэ.

4. Зардлын /цалин/ данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

2020 оны 12-р сард 11 ажилчинд 1,464.9 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон нь байгууллагын цагийн бүртгэлээр батлагдаагүй. Ажлын цагийн бүртгэл тооцоо хангалтгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2. *“төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх; үнэн зөв, тодорхой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

4.2. Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулснаар үргүй зардал өсөх.

4.3. Өгсөн зөвлөмж:

Цалингийн зардлыг тооцож олгохдоо ажлын цагийн бүртгэлд үндэслэн үнэн зөв тооцоолж байх;

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор 2020 оны 12-р сард гэрээсээ ажиллаж байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулж байсан бөгөөд захиргааны зүгээс тогтмол хяналт тавьж, цахим орчинд соёл түгээе аяны хүрээнд лайв бичлэгүүдийг хийж үзэгч багачууддаа хүргэсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Улсын хүүхэлдэйн театрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2020			САГ-2021/72/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Улсын хүүхэлдэйн театр		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт бүрэн нийцээгүй, өөрчлөн сайжруулах шаардлагатай болсон.	-	Албан шаардлага хүргүүлсэн.	Дарга Ерөнхий нягтлан бодогч	М.Отгончимэг Г.Алтанчимэг
2	Баянхонгор аймгийн Тэмүүжин театраас хүлээн авсан хүүхэлдэйн жүжгийн франчайзын орлого 3,000.0 мянган төгрөгийг мөн Дэлхийн зөн ОУБ-аас орж ирсэн тоглолтын тасалбарын үнэ 500.0 мянган төгрөгийг и-баримтаар бүртгээгүй.	3,500.0	Албан шаардлага хүргүүлсэн.	Дарга Ерөнхий нягтлан бодогч	М.Отгончимэг Г.Алтанчимэг
3	Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй. Мэдээлэл дутуу оруулсан.	139,397.5	Албан шаардлага хүргүүлсэн.	Дарга Ерөнхий нягтлан бодогч	М.Отгончимэг Г.Алтанчимэг
4	Худалдан авах ажиллагааны нээлттэй тендер шалгаруулалтын журам зөрчсөн.	17,000.0	Албан шаардлага хүргүүлсэн.	Дарга Ерөнхий нягтлан бодогч	М.Отгончимэг Г.Алтанчимэг
5	Мөнгөн хөрөнгийн зарлагын 720.0 мянган төгрөгийн дүнтэй баримтууд нь төлбөрийн и-баримт болон дэмжих анхан шатны баримтгүй.	720.0	Зөвлөмж өгсөн.	Ерөнхий нягтлан бодогч	Г.Алтанчимэг
6	Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг дансны ангилал буруу бүртгэсэн; Хөдөлгөөн ороогүй он дамжсан бараа материал бүртгэлтэй.	11,803.7	Зөвлөмж өгсөн.	Ерөнхий нягтлан бодогч	Г.Алтанчимэг
7	Үндсэн хөрөнгийн дансны ангилал буруу илэрхийлэгдсэн.	3,214.0	Зөвлөмж өгсөн.	Ерөнхий нягтлан бодогч	Г.Алтанчимэг
8	Ажилчиддаа илүү цагийн хөлсийг үндэслэлгүй тооцож олгосон.	1,464.9	Зөвлөмж өгсөн.	Дарга Ерөнхий нягтлан бодогч	М.Отгончимэг Г.Алтанчимэг
ДҮН		177,100.1			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 191/АД17-0069

Улаанбаатар хот

САГ - 2021 /72/ САГ - ТУЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын хүүхэлдэйн театрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим сайтад 149 мэдээлэл байршуулахаас 139,397,534 (Нэг зуун гучин есөн сая гурван зуун ерэн долоон мянга таван зуун гучин дөрвөн) төгрөгийн орлого, зарлагын 18 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”; 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх,” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”; Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын хүүхэлдэйн театрын дарга М.Отгончимэг, ерөнхий нягтлан бодогч Г.Алтанчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ч.ДАШДАВАА

Ц.МИШИГДОРЖ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 130/АД/70063

Улаанбаатар хот

САГ- 2021/72/СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын хүүхэлдэйн театрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Улсын хүүхэлдэйн театрын захирлын 2019 оны А/64 тоот тушаалаар батлан мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт бүрэн нийцээгүй бөгөөд өөрчлөн сайжруулаагүй байна.
- Үйл ажиллагааны орлогыг и-баримтын бүртгэл тайлантай тулгаж үзэхэд 3,500,000 (Гурван сая таван зуун мянган) төгрөгөөр зөрүүтэй байна.
- Гүүд Нэйборс ОУТББ-ын Монгол дахь төлөөлөгчийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлсэн 17,000,000.00 (арван долоон сая) төгрөгийн төсөвт өртөгтэй "Миний хөөрхөн шүдний аялал" 20 ангит жүжгийн төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг байнгын харилцдаг 3 аж ахуйн нэгжид "үнийн санал авах тухай" албан тоот хүргүүлж, нээлттэй тендер зарлаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.", мөн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна."; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно."; Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.; 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад

энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 8.4-т “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”; Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын үйл ажиллагааны онцлогт бүрэн нийцүүлж, өөрчлөн сайжруулах, үйл ажиллагааны орлогын и-баримтыг хуулийн хугацаанд бүрэн бүрдүүлж, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу хэрэгжүүлж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын хүүхэлдэйн театрын дарга М.Отгончимэг, ерөнхий нягтлан бодогч Г.Алтанчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ч.ДАШДАВАА

Ц.МИШИГДОРЖ

